

## **ЗАРЛАЛ**

### **ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 3.1-ийн “б”-г үндэслэн **Өмнөговь** аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежерийн **ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтыг** нөөцөөс зарлаж байна.

#### **Нэг. Сонгон шалгаруулалтын зорилго**

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн албан тушаалын сул орон тоог /төрийн албаны нөөцөд бүртгэлтэй/ нөөцөөс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд авах мэргэшлийн шалгалтын зорилго оршино.

- “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, “Төрийн аудитын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”, “Төрийн аудитын байгууллагад ажилд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ дүн гаргах заавар”-ыг Төрийн аудитын байгууллагын <http://www.audit.mn/> гэсэн цахим хуудсанд байршуулсан бөгөөд сонгон шалгаруулалтад оролцох иргэд энэхүү журам, заавартай заавал танилцсан байна.

#### **Хоёр. Сонгон шалгаруулалтын бүртгэл**

Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдах **боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай** шаардлагыг хангасан, тус албан тушаалд ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан сул ажлын байранд тавигдах 4 ерөнхий шаардлага (**БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ, МЭРГЭШИЛ, ТУРШЛАГА**)-ыг хангасан иргэн бүртгүүлэх боломжтой.

- ”Боловсролын шаардлага”**: Бакалаврын боловсролын зэргийн шаардлага тавигдсан ажлын байранд бакалаврын дээд боловсролын зэрэгтэй иргэн бүртгүүлэх боломжтой.
- ”Мэргэжлийн шаардлага”**: Их, дээд сургуульд суралцан эзэмшсэн үндсэн мэргэжлийг ойлгоно. Үүнд: Их эмч, нягтлан бодогч гэх мэт. /Их, дээд сургууль төгссөн диплом дээрх эзэмшсэн мэргэжлийн нэр нотолгоо болно/
- ”Мэргэшлийн шаардлага”**: Их, дээд сургуульд суралцан төгсөж, бакалаврын дээд боловсрол, тодорхой мэргэжил эзэмшсэний дараа үндсэн мэргэжлээрээ

болон өөр чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, үүний дотор тодорхой хугацаанд тухайн зарлагдсан чиглэлээр курст суралцсанаас эхлээд магистр, докторын зэрэг хамгаалсан гэх мэт сургалт, дадлагажилтад ямар нэг хэлбэрээр хамрагдсан байхыг ойлгоно. /Энэ тухай холбогдох диплом, гэрчилгээ/сертификат нотолгоо болно/

- **"Туршлагын шаардлага"**: "Мэргэжлээрээ ажилласан байх" гэснийг тухайн мэргэжлээрээ улсын болон хувийн хэвшилд ажилласныг ойлгоно. Ажилласан жилийг Иргэний хуулийн 71 дүгээр зүйлд заасан хугацаа тооцох журмын дагуу хоногоор тооцдог. Жишээ нь, мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх шаардлага тавигдсан байна гэвэл яг хоногоороо тооцоход 365 хоног гүйцсэн байх ёстой гэсэн үг. /Энэ хугацааг тооцохдоо Нийгмийн даатгалын дэвтрийн "Ажилд орсон, шилжсэн, чөлөөлсөн" гэсэн хүснэгтэд бичигдсэн ажилласан хугацааг баримтална/.

Хэрэв тухайн зарлагдсан сул ажлын байранд тавигдсан 4 ерөнхий шаардлага (боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага)-ыг бүрэн хангаагүй иргэнийг бүртгэвэл, энэ нь Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн, ёс зүйгүй үйлдэл болох тул бүртгэл явуулж байгаа ажлын хэсэг ийм иргэнийг бүртгэх боломжгүй гэдгийг урьдчилан анхааруулж байна!!!

□ Сонгон шалгаруулалтад өрсөлдөх иргэдийн материалыг Засгийн газар (хуучнаар ард кино театрын замын эсрэг талд байрлах)-ын IY байрны 3 давхарт 310 тоот өрөөнд **2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 08.30-12.30, 13.30-16.00** цагийн хооронд материал хүлээн авч бүртгэнэ.

**Гурав. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:**

- Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
- Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Мэргэшсэн байдал сертификатын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Монгол Улсын иргэний цахим үнэмлэх, түүний хуулбарын хамт;
- Ажил эрхэлдэг бол ажил байдлын тодорхойлолт;
- Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 заасан асуудлаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
- Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ;
- 4х6-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Шалгалтын үйлчилгээний төлбөр 10 000;

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

**Дөрөв. Сонгон шалгаруулалтын хуваарь, хугацаа:**

Сонгон шалгаруулалтын комиссоос байгуулсан ажлын хэсэг зарлагдсан ажлын байранд бүртгүүлэхээр хүссэн иргэдийн материалыг тухайн ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан эсэхэд нэг бүрчлэн тулган шалгаж, уг ажлын байранд тавигдсан шаардлага хангаагүй иргэний материалыг буцаана.

Ажлын байранд тавигдсан шаардлага хангаж, бүртгэгдсэн иргэдийн нэрс болон **шалгалт авах газар, хуваарийг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 20.00 цагаас хойш** Төрийн аудитын байгууллагын <http://www.audit.mn/> хуудсаар мэдээлнэ. Шалгалтыг дараах хэлбэрээр авна. Үүнд:

1. **Ерөнхий шаардлага /Анкет, диплом, гэрчилгээ, нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр/**
2. **Мэргэжлийн түвшингийн шалгалт /Хууль эрх зүйн чиглэлийн сорилын 60 хувьд зөв хариулж, босго оноог хангасан иргэн дараагийн шалгалтад орно, 40 сорилтой/**
3. **Ярилцлагын шалгалт /Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох/**
4. **Ур чадварын шалгалт /Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлт, Компьютер/**

- Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалтад орох иргэн **Иргэний үнэмлэхтэйгээ** ирэх бөгөөд байхгүй бол тухайн өдрийн цахим лавлагааг үндэслэж шалгалтад оруулна.

### **Тав. Ажлын байранд тавигдсан шаардлага**

Сонгон шалгаруулалтад орох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна: Үүнд:

1. **Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн ажлын байрны шаардлага:**

	<b>Чухал шаардлагатай</b>	<b>Шаардлагатай</b>
Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш	Магистр зэрэгтэй байх
Мэргэжил	Эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, төрийн удирдлага	
Мэргэшил	Эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх.	Мэргэшсэн нягтлан бодогч
Туршлага	Төрийн албанд болон мэргэжлээрээ 8-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	-Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлтийн ур чадвар эзэмшсэн байх; -Баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ур чадвартай байх;	

	-Хууль зүйн зохих мэдлэгтэй байх; -Компьютерийн өргөн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн байх; - Удирдан зохион байгуулах чадвартай байх. -Харилцааны соёлтой байх	
Тусгай шаардлага	-Багаар ажиллах чадвартай байх; - НҮБ-д хүлээн зөвшөөрөгдсөн аль нэг гадаад хэлний зохих түвшиний мэдлэгтэй байх; -Төрийн болон байгууллага, иргэдийн нууцыг хадгалах; -Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх;	

Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар Төрийн аудитын байгууллагын Тамгын газрын Хүний нөөцийн албаны 261585 утсаар холбогдож лавлагаа авч болно.

### **Зургаа. Сонгон шалгаруулалтад орох иргэдийн уншиж судлах эрх зүйн баримт бичиг**

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтын хүрээнд бэлтгэсэн “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын сорилгын хураамж” Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн номын худалдаанд зарагдаж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтад орох иргэд дараах жагсаалтад байгаа хууль, журмаас бэлдэнэ үү. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль,
3. Төрийн бэлэг тэмдгийн тухай хууль,
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль,
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль,
7. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
8. Төрийн албаны тухай хууль,
9. Төрийн албан ёсны хэлний тухай хууль,
10. Төрийн нууцын тухай хууль,
11. Авлигын эсрэг хууль,
12. Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
13. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
14. Хөдөлмөрийн тухай хууль,
15. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
16. Төрийн болон албаны тухай
17. Татварын ерөнхий хууль,
18. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
19. Нийгмийн даатгалын тухай хууль,

20. Нийгмийн халамжийн тухай хууль,
21. Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
22. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,
23. Шилэн дансны тухай хууль,
24. Архивын тухай хууль,
25. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль
26. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай
27. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
28. Төсвийн тухай хууль
29. Төсвийн тогтвортой байдлын тухай
30. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.
31. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
32. Захиргааны ерөнхий хууль /2016.07.01/
33. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2016.07.01/
34. Нийтийн сонсголын тухай хууль
35. Төрийн аудитын тухай хууль
36. Хууль тогтоомжийн тухай хууль
37. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
38. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал,
39. Тогтвортой хөгжил-2030
40. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм

**ХАРИЛЦАХ ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН 4 ДҮГЭЭР БАЙР,**

310 ТООТ ӨРӨӨ, УТАС: 261585, 62263230